



Монголын Радиологийн Нийгэмлэгийн
Удирдах Ажилтны Зөвлөгөөн-2019
2019 оны 04-р сарын 06-ны өдрийн
хурлаар Дүрс Оношилгоо судлалын
зэргийн шалгалтын журмыг шинэчлэн
боловсруулан батлагдав.

БАТЛАВ.



МОНГОЛЫН РАДИОЛОГИЙН
НИЙГЭМЛЭГИЙН ТЭРГҮҮН,
ЕРӨНХИЙЛӨГЧ

2023-01-16

Д.ГОНЧИГСҮРЭН

ДҮРС ОНОШИЛГОО СУДЛАЛ ҮНДСЭН МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ГОРИЛОГЧИД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРЛАГА

Энэхүү тусгай шаардлагыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл зөвшөөрсөн өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай мөрдөнө.

1. **АХЛАХ** зэрэг горилогч эмч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 1.1 Журмын дагуу нийтлэг шаардлагыг хангасан байна.
 - 1.2 Дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 1.2.1 Мэргэжлийн чиглэлээр эрдэм шинжилгээний хурлын илтгэл (гадаад болон дотоод, илтгэлийн хураангуй) нийт ажиллах явцдаа жилд 1-ээс доошгүй удаа буюу 8-аас доошгүйг бичиж хэвлүүлсэн байх, хураангуй, номноос баталгаажсан хуулбар
 - 1.2.2 Мэргэжлээрээ 8 жил ажиллах хугацаанд “Радиологи” сэтгүүлд нэгдүгээр болон хамтарсан зохиогчоор эрдэм шинжилгээний өгүүлэл, эмнэлзүйн ховор тохиолдол 2-оос доошгүй хэвлүүлэх. Эдгээрийн 1-ээс доошгүйг нэгдүгээр зохиогчоор хэвлүүлсэн байх
 - 1.2.3 Мэргэжлийн нийгэмлэг холбооны зохион байгуулсан хурал семинарт сүүлийн 5 жил тасралтгүй хамрагдсан байх, гэрчилгээний хуулбараар баталгаажуулах
 - 1.2.4 Дүрс оношилгооны мэргэжил дээшлүүлэх сургалтанд 1 сараас доошгүй хугацаанд хамрагдсан байх, сургалт эрхлэх эрх бүхий байгууллагын гэрчилгээний хуулбараар баталгаажуулах

2. **ТЭРГҮҮЛЭХ** зэрэг горилогч эмч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1 Журмын дагуу нийтлэг шаардлагыг хангасан байна.

2.2 Дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.2.1 Мэргэжлийн нийгэмлэг холбооны зохион байгуулсан хурал семинарт ахлах зэрэг олгогдсоноос хойш 5 жил тасралтгүй хамрагдсан байх, сертификатын хуулбараар баталгаажуулах

2.2.2 Оношилгоо эмчилгээний стандарт, удирдамж боловсруулах багт ажилласан байх (3-с доошгүй), хуулбараар баталгаажуулах

2.2.3 Эрдэм шинжилгээний хурлын илтгэл (гадаад болон дотоод илтгэлийн хураангуй) нийт ажиллах хугацаандаа жилд 1-ээс доошгүй удаа буюу ахлах зэрэг олгогдсоноос хойш 5-аас доошгүйг бичиж хэвлүүлсэн байх, илтгэлийн хураангуй, номны хуулбараар баталгаажуулах

2.2.4 Ахлах зэрэг хамгаалснаас хойш 5 жилийн хугацаанд “Радиологи” сэтгүүлд нэгдүгээр болон хамтарсан зохиогчоор эрдэм шинжилгээ, сургалтын өгүүлэл, эмнэлзүйн ховор тохиолдол 2-оос доошгүй хэвлүүлэх. Эдгээрийн 2-ээс доошгүй өгүүллийг нэгдүгээр зохиогчоор хэвлүүлсэн байх (Үүнд эмнэлзүйн тохиоодол хамаарахгүй).

2.2.5 Үндэсний хэмжээний сургалт, семинар зохион байгуулахад оролцсон байх, баталгаажуулах

2.2.6 Дүрслэл оношлогооны чиглэлээр төгсөлтийн өмнөх болон дараах сургалт, дадлагын үйл ажиллагааг удирдсан байх, байгууллагын тушаалаар баталгаажуулах

2.2.7 Дүрс оношилгооны чиглэлээр төрөлжсөн нарийн мэргэжил эзэмшсэн байх, сертификат, гэрчилгээгээр баталгаажуулах

3. **ЗӨВЛӨХ** зэрэг горилогч эмч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 3.1 Журмын дагуу нийтлэг шаардлагыг хангасан байна.
 - 3.2 Дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 3.2.1 Тэргүүлэх зэрэг олгогдсоноос хойш 5-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх, албан газрын тодорхойлолт нийгмийн даатгалын хуулбараар баталгаажуулах
 - 3.2.2 Мэргэжлийн чиглэлээр олон улсын болон үндэсний хурал семинар чуулган зохион байгуулсан болон хурал удирдаж байсан, хуулбараар баталгаажуулах
 - 3.2.3 Боловсруулсан оношлогоо эмчилгээний стандарт 3-аас доошгүй, бичиж туурвисан ном, гарын авлага, удирдамж 3-аас доошгүй тус тус байх, хуулбараар баталгаажуулах
 - 3.2.4 Эрдэм шинжилгээний хурлын илтгэл (гадаад болон дотоод илтгэлийн хураангуй 20-аас доошгүй байх), хуулбараар баталгаажуулах
 - 3.2.5 Тэргүүлэх зэрэг хамгаалснаас хойш “Радиологи” сэтгүүлд нэгдүгээр болон хамтарсан зохиогчоор эрдэм шинжилгээ, сургалт, тойм өгүүлэл, эмнэлзүйн ховор тохиолдол 5-аас доошгүй хэвлүүлэх. Эдгээрийн 3-оос доошгүй өгүүллийг нэгдүгээр зохиогчоор хэвлүүлсэн байх
 - 3.2.6 Дүрслэл оношлогооны эмчийн мэргэжил олгох, мэргэшүүлэх болон дадлагажуулах сургалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, багшилж байсан туршлагатай.
 - 3.2.7 Анагаах ухааны докторын зэрэгтэй байх, гэрчилгээний хуулбар

Монголын Радиологийн Нийгэмлэгийн Удирдах Ажилтны
Зөвлөгөөн-2019 2019 оны 04-р сарын 06-ны өдрийн
хурлаар Дүрс Оношилгоо судлалын зэргийн шалгалтын
журмыг шинэчлэн боловсруулан батлагдав.

БАТЛАВ.



МОНГОЛЫН РАДИОЛОГИЙН
НИЙГЭМЛЭГИЙН ТЭРГҮҮН,
ЕРӨНХИЙЛӨГЧ

2023-01-16

Д.ГОНЧИГСҮРЭН

ДҮРС ОНОШИЛГООНЫ ТЕХНИКЧ МЭРГЭЖЛЭЭР ЗЭРЭГ ГОРИЛОГЧ НАРТ ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРЛАГА

Энэхүү тусгай шаардлагыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл зөвшөөрсөн өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай мөрдөнө.

1. АХЛАХ зэрэг горилогч техникч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна.
Үүнд:

1.1 Журмын дагуу нийтлэг шаардлагыг хангасан байна.

1.2 Дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 1.2.1 Эрдэм шинжилгээний хурлын илтгэл /гадаад болон дотоод илтгэлийн хураангуй/ Нийт ажиллах явцдаа 5-аас доошгүйг бичиж хэвлүүлсэн байх, хуулбараар баталгаажуулах
- 1.2.2 Мэргэжлийн нийгэмлэгийн хуралд сүүлийн 5 жил тасралтгүй оролцсон байх, сертификатаар баталгаажих
- 1.2.3 Компьютерийн хэрэглээний программ дээр ажиллах чадвартай байх
- 1.2.4 Дүрс оношлогооны техникчийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан байх, хуулбараар баталгаажуулах

2. ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилоч техникч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1 Журмын дагуу нийтлэг шаардлагыг хангасан байна.

2.2 Дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.2.1 Мэргэжлийн нийгэмлэгийн хуралд сүүлийн 5 жил тасралтгүй оролцсон байх, сертификатаар баталгаажих

2.2.2 Эрдэм шинжилгээний хурлын илтгэл /гадаад болон дотоод илтгэлийн хураангуй/ ахлах зэрэг олгогдсоноос хойш 5-аас доошгүйг бичиж хэвлүүлсэн байх, хураангуйг баталгаажуулсан байх

2.2.3 Олон улсын болон үндэсний хэмжээний дүрс оношлогооны техникчийн сургалт ба семинарт оролцож, зохион байгуулсан байх

2.2.4 Дүрс оношлогооны техникчийн мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан байх, гэрчилгээгээр баталгаажуулах.

2.2.5 PACS болон дотоод сүлжээг ашигладаг чадвартай байх

3. ЗӨВЛӨХ зэрэг горилогч техникч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна.

Үүнд:

3.1 Журмын дагуу нийтлэг шаардлагыг хангасан байна.

3.2 Дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.2.1 Тэргүүлэх зэрэг олгогдсоноос хойш 5-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх, албан газрын тодорхойлолт нийгмийн даатгалын хуулбараар баталгаажуулах

3.2.1 Мэргэжлийн чиглэлээр олон улсын болон үндэсний хурал семинар чуулган зохион байгуулсан болон хурал удирдаж байсан, хуулбараар баталгаажуулах

3.2.2 Боловсруулсан оношлогоо эмчилгээний стандартай, бичиж туурвисан ном, гарын авлага, удирдамжтай байх, хуулбараар баталгаажуулах

3.2.3 Эрдэм шинжилгээний хурлын илтгэл (гадаад болон дотоод илтгэлийн хураангуй 15-аас доошгүй байх), хуулбараар баталгаажуулах

3.2.4 Тэргүүлэх зэрэг хамгаалснаас хойш “Радиологи” сэтгүүлд нэгдүгээр болон хамтарсан зохиогчоор эрдэм шинжилгээ, сургалт, тойм өгүүлэл, эмнэлзүйн ховор тохиолдол 3-аас доошгүй хэвлүүлэх. Эдгээрийн 2-оос доошгүй өгүүллийг нэгдүгээр зохиогчоор хэвлүүлсэн байх

3.2.5 Дүрслэл оношлогооны техникчийн мэргэжил олгох, мэргэшүүлэх болон дадлагажуулах сургалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, багшилж байсан туршлагатай.